



### **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Алтанцөгц сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/25/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: Khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Үүрийнтуяа Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал .....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	17
3.8 Аудитын гол асуудал .....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт .....	19
4.1 Залруулсан алдаа.....	19
4.2 Төлбөрийн акт.....	19
Байхгүй .....	19
4.3 Албан шаардлага .....	19
4.4 Зөвлөмж .....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

АЛТАНЦӨГЦ СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА А.ЕРХАНАТ ТАНАА

2022.02.24 № 131  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>7,812,000.00</u></b>	<b><u>7,767,000.00</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
31110	Төгрөг	-	-
31140	Касс арилжааны банк	-	-
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31213	Арилжааны банк дахь харилцах	-	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	7,812,000.00	7,767,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	7,812,000.00	7,767,000.00
35410	Бичиг хэргийн материал	70,000.00	
35420	Аж ахуйн материал	7,742,000.00	7,767,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	-
35440	Түлш, шатах тослох материал		
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>919,976,213.27</u></b>	<b><u>914,928,970.75</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	919,976,213.27	914,928,970.75
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	915,251,372.99	910,679,130.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	668,835,050.48	668,835,050.48
39202	Хуримтлагдсан элэгдэл	(47,363,891.28)	(71,279,614.32)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	137,518,700.00	147,518,700.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(123,733,699.92)	(129,558,699.96)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	257,300,071.00	258,800,071.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(228,137,317.55)	(235,401,652.75)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	57,512,383.00	57,512,383.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(53,908,175.08)	(54,509,951.08)
39214	Бусад үндсэн хөрөнгө	701,168,759.90	723,268,759.90
39215	Хуримтлагдсан элэгдэл	(453,940,507.56)	(514,326,915.84)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	4,724,840.28	4,249,840.32
39301	Програм хангамж	7,133,400.00	7,133,400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,232,559.72)	(5,707,559.68)

Алтанцөгц сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

39303	Бусад биет бус хөрөнгө	2,824,000.00	2,824,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>927,788,213.27</u></b>	<b><u>922,695,970.75</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>13,288,729.00</u></b>	<b>=</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	13,288,729.00	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	13,288,729.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	12,435,329.00	
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	853,400.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	853,400.00	
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>914,499,484.27</u></b>	<b><u>922,695,970.75</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	914,499,484.27	922,695,970.75
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,117,898,267.00	1,117,898,267.00
51101	Өмч: - төрийн	1,117,898,267.00	1,117,898,267.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(758,067,114.85)	(749,870,628.37)
51210	Өмнөх үеийн үр дүн	(696,902,928.71)	(758,067,114.85)
51220	Тайлант үеийн үр дүн	(61,164,186.14)	8,196,486.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	554,668,332.12	554,668,332.12
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>927,788,213.27</u></b>	<b><u>922,695,970.75</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>366,754,476.00</b>	<b>466,979,852.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,700,000.00</b>	-
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,700,000.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	4,700,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,700,000.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>362,054,476.00</b>	<b>466,979,852.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	7,913,376.00	11,919,852.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,913,376.00	11,919,852.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	354,141,100.00	455,060,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	292,107,800.00	345,239,000.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	62,033,300.00	109,821,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>427,918,662.14</b>	<b>458,783,365.52</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>427,918,662.14</b>	<b>458,783,365.52</b>

Алтанцөгц сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	427,738,662.14	417,404,365.52
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	214,696,947.00	211,166,190.00
210101	Үндсэн цалин	148,401,745.00	147,999,990.00
210102	Нэмэгдэл	46,541,202.00	43,672,300.00
210105	Гэрээт ажлын хөлс	19,754,000.00	19,493,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27,762,341.00	27,778,681.00
210201	Тэтгэврийн даатгал	27,762,341.00	27,778,681.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	26,769,880.00	23,390,800.00
210301	Гэрэл, цахилгаан	1,150,800.00	1,104,800.00
210302	Түлш, халаалт	25,619,080.00	22,286,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18,025,574.00	10,186,491.00
210401	Бичиг хэрэг	3,084,950.00	2,365,100.00
210402	Тээвэр, шатахуун	13,246,644.00	6,749,202.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,693,980.00	995,400.00
210404	Ном, хэвлэл	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	76,789.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	690,780.00	884,810.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-
210502	Хоол, хүнс	-	730,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	690,780.00	154,810.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	689,730.00	1,275,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
210604	Урсгал засвар	689,730.00	1,275,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	983,300.00	1,669,600.00
210702	Дотоод албан томилолт	983,300.00	1,669,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,715,120.00	1,291,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	516,720.00	150,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	427,600.00	302,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,300.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	211,900.00	176,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	95,600.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	219,600.00	394,100.00
210807	Газрын төлбөр	45,600.00	37,300.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	89,800.00	65,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	136,404,990.14	139,761,493.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,057,212.00	23,103,251.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	535,970.00	290,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	121,811,808.14	116,368,242.52
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	180,000.00	41,379,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	41,199,000.00

Алтанцөгц сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	41,199,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	180,000.00	180,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	180,000.00	180,000.00
213404	Хөрөнгийн	-	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	-
220001	Барилга байгууламж	-	-
221001	Их засвар	-	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(61,164,186.14)</b>	<b>8,196,486.48</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	-
145003	Хөрөнгө оруулалтын олз	-	-
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
225002	Найдваргүй авлагын алдагдал	-	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(61,164,186.14)</b>	<b>8,196,486.48</b>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,117,898,267.00	554,668,332.12	(758,067,114.85)	914,499,484.27
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,117,898,267.00	554,668,332.12	(758,067,114.85)	914,499,484.27
C04	Үндсэн хөрөнгийн дахин				-
C07	Тайлант үеийн үр дүн				-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,117,898,267.00	554,668,332.12	(758,067,114.85)	914,499,484.27
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,117,898,267.00	554,668,332.12	(758,067,114.85)	914,499,484.27
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,117,898,267.00	554,668,332.12	(758,067,114.85)	914,499,484.27
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D08	Тайлант үеийн үр дүн			8,196,486.48	8,196,486.48
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,117,898,267.00	554,668,332.12	(749,870,628.37)	922,695,970.75

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>300,021,176.00</u></b>	<b><u>357,158,852.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	-
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	-
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>300,021,176.00</b>	<b>357,158,852.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	7,913,376.00	11,919,852.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,913,376.00	11,919,852.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	292,107,800.00	345,239,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	292,107,800.00	345,239,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>300,021,176.00</u></b>	<b><u>355,658,852.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>300,021,176.00</b>	<b>355,658,852.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>299,841,176.00</b>	<b>314,279,852.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	204,045,500.00	222,325,900.00
210101	Үндсэн цалин	137,247,500.00	159,159,700.00
210102	Нэмэгдэл	47,041,200.00	43,672,300.00
210105	Гэрээт ажлын хөлс	19,756,800.00	19,493,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27,546,200.00	29,054,300.00
210201	Тэтгэврийн даатгал	19,384,400.00	20,445,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,040,500.00	2,152,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,632,300.00	1,721,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	408,100.00	430,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,080,900.00	4,304,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	27,423,200.00	23,500,800.00
210301	Гэрэл, цахилгаан	1,130,800.00	1,104,800.00
210302	Түлш, халаалт	26,292,400.00	22,396,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	15,669,124.00	10,343,403.00
210401	Бичиг хэрэг	2,802,700.00	2,183,700.00
210402	Тээвэр, шатахуун	11,104,224.00	7,076,303.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,762,200.00	995,400.00
210404	Ном, хэвлэл		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		88,000.00

Алтанцөгц сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	458,300.00	958,600.00
210502	Хоол, хүнс		730,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	458,300.00	228,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,707,700.00	1,215,100.00
210604	Урсгал засвар	2,707,700.00	1,215,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,819,000.00	1,669,600.00
210702	Дотоод албан томилолт	4,819,000.00	1,669,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,024,900.00	1,275,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	608,000.00	150,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	427,600.00	302,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,300.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	211,900.00	176,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	95,600.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	438,100.00	378,700.00
210807	Газрын төлбөр	45,600.00	37,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	89,800.00	65,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	15,147,252.00	23,936,349.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,597,252.00	23,519,549.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,000.00	416,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>180,000.00</b>	<b>41,379,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	41,199,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		41,199,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	180,000.00	180,000.00
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	180,000.00	180,000.00
213404	Хөрөнгийн		
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	=	<b><u>1,500,000.00</u></b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	-	-
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
140002	Улсын төсвөөс олгосон зээл		
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>1,500,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>1,500,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	1,500,000.00
220001	Барилга байгууламж		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		1,500,000.00

6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	=	<b><u>(1,500,000.00)</u></b>
14	<b>Бусад эх үүсвэр</b>	-	-
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		
145005	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх		
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	=	=
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>345,239,000.00</b>	<b>345,239,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>345,239,000.00</b>	<b>345,239,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	304,040,000.00	304,040,000.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	222,325,900.00	222,325,900.00
210101	Үндсэн цалин	159,159,700.00	159,159,700.00
210102	Нэмэгдэл	43,672,300.00	43,672,300.00
210105	Гэрээт ажлын хөлс	19,493,900.00	19,493,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,054,300.00	29,054,300.00
210201	Тэтгэврийн даатгал	20,445,700.00	20,445,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,152,100.00	2,152,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,721,700.00	1,721,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	430,400.00	430,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,304,400.00	4,304,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	23,500,800.00	23,500,800.00
210301	Гэрэл, цахилгаан	1,104,800.00	1,104,800.00
210302	Түлш, халаалт	22,396,000.00	22,396,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,853,100.00	7,853,100.00
210401	Бичиг хэрэг	2,183,700.00	2,183,700.00
210402	Тээвэр, шатахуун	4,586,000.00	4,586,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	995,400.00	995,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	88,000.00	88,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	228,600.00	228,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	228,600.00	228,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,715,100.00	1,715,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	715,100.00	715,100.00

Алтанцөгц сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,669,600.00	1,669,600.00
210702	Дотоод албан томилолт	1,669,600.00	1,669,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,275,800.00	1,275,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,400.00	150,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	302,200.00	302,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	90,300.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	176,900.00	176,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	378,700.00	378,700.00
210807	Газрын төлбөр	37,300.00	37,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	65,000.00	65,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	16,416,800.00	16,416,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,000,000.00	16,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	416,800.00	416,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	41,199,000.00	41,199,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	41,199,000.00	41,199,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	41,199,000.00	41,199,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>345,239,000.00</b>	<b>345,239,000.00</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	345,239,000.00	345,239,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	345,239,000.00	345,239,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>23</b>	<b>21</b>
620001	Удирдах ажилтан	7	7
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	2	1
620004	Гэрээт ажилтан	5	4
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>23</b>	<b>21</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	8
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	4
650010	Гэрээт ажилтан	3	3
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>7,913,376.00</b>	<b>11,919,852.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>7,913,376.00</b>	<b>11,919,852.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	7,733,376.00	11,739,852.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	-
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,136,124.00	2,490,303.00
210401	Бичиг хэрэг	230,000.00	
210402	Тээвэр, шатахуун	1,716,824.00	2,490,303.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	189,300.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	730,000.00
210502	Хоол, хүнс		730,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	1,000,000.00
210604	Урсгал засвар		1,000,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,597,252.00	7,519,549.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,597,252.00	7,519,549.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	-
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>180,000.00</b>	<b>180,000.00</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	180,000.00	180,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	7,913,376.00	11,919,852.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	7,913,376.00	11,919,852.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,913,376.00	11,919,852.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн №2/12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газар нь Төрийн албаны болон холбогдох хууль тогтоомжуудыг ажилдаа мөрдлөг болгож, авлига, ашиг сонирхлын зөрчилд автахгүй. Үйл ажиллагаандаа төрийн албаны стандартыг дагаж мөрдөн, дотоод ажлыг сайжруулна. Ажлын цагийн ашиглалтыг сайжруулж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний ажлын хөнгөн шуурхай байдлыг хангана. Байгууллагын санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд ил тод байдлыг хангаж ажиллана гэсэн зорилго, зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус газарт дотоод аудитор ажилладаггүй, тайлант онд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 427.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 8.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5.0 сая төгрөгөөр буюу 0.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт:

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага			-
Урьдчилгаа			-
Бараа материал	7,812.0	7,767.0	(45.0)
Үндсэн хөрөнгө	919,976.2	914,929.0	(5,047.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>927,788.2</b>	<b>922,696.0</b>	<b>(5,092.2)</b>
Өр төлбөр	13,288.7		(13,288.7)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	914,499.5	922,696.0	8,196.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>927,788.2</b>	<b>922,696.0</b>	<b>(5,092.2)</b>

Мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал дансанд үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 7.8 төгрөг болж 0.04 сая төгрөгөөр буурч, тайлант онд 13.9 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 14.0 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 914.9 сая төгрөг болж 5.0 сая төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл худалдан авсан болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө, үндсэн хөрөнгийн элэгдэл, акталсан хөрөнгийн зөрүүгээр буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1.5 сая төгрөгийн, аймгийн ОНХС-гаас 94.8 сая, сумын ОНХС-гаас 15.0 сая, нийт 111.3 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 65 тоот тогтоолоор 19.7 сая төгрөгийн гүүрийг акталсан байна.

Өр төлбөр дансан дахь оны эхний 13.3 сая төгрөгийн өглөгийг бүрэн барагдуулж, оны эцэст өглөггүй, Засгийн газрын оролцоо дансанд өөрчлөлт гараагүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 466.9 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 100.2 сая төгрөгөөр буюу 27.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсвийн урсгал санхүүжилт, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 30.9 сая төгрөгөөр буюу 7.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нормативт зардал, бараа үйлчилгээний зардал, тэтгэвэр тэтгэмжийн зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт гараагүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны ээлжит II хуралдааны 16 дугаар тогтоолоор тус газрын төсвийг орон нутгийн төсвөөс 325.2 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны Төсвийн сарын зохицуулсан хуваарь батлах тухай А/1093 тоот захирамжаар тус газрын батлагдсан төсвийг 345.2 сая төгрөг болгон өөрчилсөн байна.

Энэ нь анх батлагдсан төсвөөс түлшний зардлаас 0.3 сая, шатахууны зардлаас 0.1 сая, нормын хувцас зөөлөн эдлэлээс 0.2 сая, урсгал засвар 0.4 сая, томилолтын зардлаас 1 сая төгрөгөөр бууруулж, цалин зардлыг 7.1 сая, багаж техник хэрэгслийн зардлыг 1.0 сая, бараа үйлчилгээний бусад зардалд аймгийн Засаг дарга давсан хэсгээс 14.0 сая төгрөгөөр, нийтдээ 20.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 345.2 сая төгрөгийн төсөв баталснаас гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 345.2 сая төгрөг төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаанд зарцуулсан байна.

**Хүснэгт 2. Хөтөлбөр арга хэмжээ, батлагдсан төсөв гүйцэтгэл**

*/мянган төгрөгөөр/*

№	Хөтөлбөр	Арга хэмжээ	Нэршил	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	70106	70106	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага			
2		80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	244101.0	244101.0	-
3		80102	Туслах үйл ажиллагааны зардал	47939.0	47939.0	-
4		80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	41199.0	41199.0	-
5		81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	12000.0	12000.0	-
<b>Нийт дүн</b>				<b>345239.0</b>	<b>345239.0</b>	<b>-</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 11.9 төгрөгийн санхүүжилт хүлээн авчээ. Статистикийн хэлтсээс мал тооллогын зардал, судалгааны зардлаас 1.0 сая, Тусгаарлалтын зардлаас 5.0 сая, Орон нутгийн хөгжлийн сангийн хяналтын зардлаас 1.3 төгрөгийг, сумын Төрийн банкнаас байрны түрээсийн орлогод 2.3 сая төгрөгийг, бусад эх үүсвэрээс 2.3 сая төгрөгийг бүрдүүлэн зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийг 1 хөтөлбөр, 1 төсөл арга хэмжээний зардалд 2.5 сая төгрөгийг хангамжийн зардалд, 0.7 сая төгрөгийг хоолны зардалд, 1.0 сая төгрөгийн багаж техникийн зардалд, 7.5 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлуудад тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын бэлтгэж ирүүлсэн 2021 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал ороогүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай цалингийн зардалд 222.3 сая төгрөг, НДШ-ийн зардалд 29.1 сая төгрөг, халаалтын зардалд 22.4 сая төгрөг, шатахууны зардалд 4.6 сая төгрөг, тэтгэмжийн зардалд 41.2 сая, бараа үйлчилгээний зардал буюу ковид-19-ийн зардалд 16 сая 32.5 сая төгрөг нийтдээ 335.6 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэл нийт 345.2 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлын дүн 335.6 сая төгрөгийг хасахад 9.7 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 2021 онд төсвөөс 1.0 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллахаар тооцоо гарч байна.

Өмнөх онд цалингийн сангийн дутуу батлагдсантай холбоотой 13.3 сая төгрөгийн өглөгийг төсвийн хэмнэлттэй гарсан зардлаас гүйлгэн зарцуулах эрх авч бүрэн барагдуулж ажилласанаар төсөв хэмнэх боломж гараагүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд нийт 345.2 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 345.2 сая 119 мэдээллийг хугацаанд ил тод байршуулсан байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц онц асуудал байхгүй, санхүүгийн тайлангийн аудитыг түүврийн аргаар эрсдэлд тооцож үзсэн тул төсвийн зарцуулалтыг бүрэн үзэх шаардлагатай байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

### 4.1 Залруулсан алдаа

Байхгүй

### 4.2 Төлбөрийн акт

Байхгүй

### 4.3 Албан шаардлага

Байхгүй

### 4.4 Зөвлөмж

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн